

Хүсэлт

Ялгаатай элементүүдийг агуулах $a[1..n]$ хүснэгт өгөгдсөн бол таны бичих програм дараах $Q(i, j, k)$ загвартай цуврал асуултанд хариулах ёстой. Өөрөөр хэлбэл $a[i..j]$ дэд хүснэгтэнд k -ээс эрс бага хичээн элемент байгааг хариулах юм.

Хязгаарлалт:

- $1 \leq n \leq 150000$
- $1 \leq q \leq 100000$
- $1 \leq a[i] \leq 10^9$

Оролт:

Эхний мөрөнд хүснэгтийн хэмжээ болох n болон нийт асуултын тоог илэрхийлэх q тоонууд зайгаар тусгаарлагдан байрлана. Хоёр дахь мөрөнд n ширхэг ялгаатай тоонууд зайгаар тусгаарлагдан байрлана. Дараагийн q ширхэг мөр бүр i, j, k гэсэн тоонуудыг харгалзан илэрхийлэх 3 тоо нь зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

Гаралт:

q ширхэг асуултын хариу бүр нэг нэг мөрөнд хэвлэгдэнэ.

Жишээ 1:

bing.in

10 5

3 1 5 7 9 2 10 4 6 8

5 6 9

5 9 9

3 7 7

1 10 6

4 5 7

bing.out

1

3

2

5

0